



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



# НИЙГЭМ СУДЛАЛ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

**САНАМЖ**

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

Дараах тохиолдлуудыг уншаад 1-9 дүгээр даалгаврыг гүйцэтгээрэй.



Ганчимэг нь 7а ангийн анги удирдсан багш. Ганчимэг багшийн ангид Дорж, Бат хоёр сурдаг сурдаг. Дорж өдөр бүр хичээлдээ ангийнхаа сурагч Баттай хамт явдаг бөгөөд уулзахдаа сайхан амарсан уу? гэж гар барин мэндэлдэг. Сурагч Дорж нь үргэлж инээмсэглэж явдаг бөгөөд ангийн бүх сурагчтай найрсаг, хөгжилтэй харилцдаг эгэл даруухан хөвгүүн билээ. Тэр хичээл бүр дээрээ өөрийн сурах арга барилд тулгуурлан суралцдаг. Тухайлбал: Бусдыг хүндэтгэх, бусадтай зөв ойлголцох арга чадвар юм. Тухайн хичээлийн мэдлэгийг өөрт таарч буй асуудлаа зөв шийдэх арга хэрэгсэл болгож чаддаг билээ. Мөн аливаа зүйлд шударга, шударга бус, ашигтай, ашиггүй гэх мэт олон янз байдал байдгийг өвөө, эмээгийнхээ сургаал номлолын үндсэн дээр сурсан. Харин бусад хүнтэй, байгальтай, эд юмстай харилцах харилцааг журамлаж, зөв сайхан амьдрах арга ухаанд суралцах зүйлийг эцэг, эхийн хүмүүжлээр сурсан билээ. Сурагч Дорж нь өвөө, эмээ, эцэг, эхээс сурч мэдсэн зүйлдээ тулгуурлан юмс, үзэгдлийн тодорхой шинж чанарыг илэрхийлсэн дүрс, дүрслэлээр маш сайхан бүтээл хийж найз нөхөд, багш нартаа танилцуулжээ.

Харин сурагч Бат нь хичээлийн хоцрогдолтой бөгөөд бусад сурагчдыг хичээл сургалтын үеэр нь шоглож байдаг дэггүй сурагч юм. Тэр сургууль дээрээ зөрчил гаргасан бөгөөд сургуулийн удирдлагаас Ганчимэг багшийг дуудаж ангийн сурагч нь сургуульд зөрчил удаа дараа гаргасан учир анги даалтын мөнгийг нь хассан. Ангийн багш Ганчимэг нь эцэг эхийн хурал хийсний дараа Батын болон зарим сурагчдын эцэг, эхтэй ганцаарчлан уулзаж хичээл сургалтад нь илүү анхаарч дэмжиж ажиллаарай гэсэн чиг үүрэг өгчээ. Харин Доржийн гэрээс аав нь ирж эцэг эхийн хуралд суусан. Түүний аав нь урлаг, дуу хөгжим сонирхдог бөгөөд урт хар үс болон өмссөн хувцас нь бусад сурагчын анхаарлыг татлаа.



Ангийн багш Ганчимэг нь орон нутгийн байгууллагуудаас зохион байгуулж буй “Хүүхдийн эрхийг хамгаалах” сургалтад Дорж, Бат хоёрыг сууж ангийнхандаа “Хүүхдийн эрхийг хамгаалах” сургалтын талаар мэдээлэл өгөөрэй гэж хэлэв.



Бат Дорж хоёр хөл бөмбөг тоглох сонирхолтой бөгөөд хөл бөмбөгийн дэлхийн аваргын тоглолт дээр санаа бодол нь зөрчилдөж маргаан үүссэн. Тэр хоёр зөрчилдсөн ч гэсэн нэгнийхээ дэмждэг багийн тоглогчийг хэн хэн нь илүү гэдэг санаан дээр зөрчилдсөнөө ойлгож эхэлсэн билээ. Гэсэн ч Бат, Доржид буулт хийж чадалгүй өөрийн дэмждэг багийнхаа тоглогчийг бусад багуудтай харьцуулан илүү гэж зөрчилдсөөр байсан. Тэрхүү зөрчил нь илүү хурцадмал байдалд орж Бат Доржийн хөл рүү цохиж бэртэл учруулжээ. Маргааш нь Доржийн ээж, аав нь Батын эцэг эхтэй уулзаж тэрхүү зөрчил маргааныг шийдвэрлэсэн.

1. Дээрх тохиолдлууд юуны тухай өгүүлж байна вэ?
  - A. Нийгмийн бүлэг болон нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцаа, зөрчил маргаан болон үе шатын тухай
  - B. Нийгмийн бүлэг болон харилцааны бүс, зөрчил маргаан, зөрчил маргааны үе шат, хувь хүний соёлын бүрдэл хэсгүүдийн тухай
  - C. Хувь хүн ба нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцаа болон хувь хүний соёлын бүрдэл хэсгүүд болон соёлын олон янз байдлын тухай
  - D. Нийгмийн бүлгийн хоорондын харилцаа, зөрчил маргаан, хувь хүний соёлын бүрдэл хэсгүүд болон соёлын олон янз байдлын тухай
2. Анхдагч бүлэгт хэн хамаарч байна вэ?
  - A. Сурагчдын гэр бүл
  - B. 7а бүлэг
  - C. Сургууль болон сургуулийн удирдлагууд
  - D. Орон нутгийн байгууллагууд
3. Хувийн харилцааны бүсэд аль хэсэг нь хамаарч байна вэ?
  - A. Дорж үргэлж ангийн бүх сурагчтай найрсаг, хөгжилтэй харилцдаг
  - B. Дорж өдөр бүр хичээлдээ ангийнхаа сурагч Баттай хамт явдаг.
  - C. Дорж, Бат хоёр уулзахдаа сайхан амарсан уу? гэж гар барин мэндэлдэг.
  - D. “Хүүхдийн эрхийг хамгаалах” сургалтад Дорж, Бат хоёр сууж мэдээлэл авсан
4. Албан ёсны харилцааны бүсэд аль хэсэг нь хамаарч байна вэ?
  - A. Дорж өдөр бүр хичээлдээ ангийнхаа Баттай хамт явдаг.
  - B. Дорж үргэлж ангийн бүх сурагчтай найрсаг, хөгжилтэй харилцдаг
  - C. Дорж, Бат хоёр уулзахдаа сайхан амарсан уу? гэж гар барин мэндэлдэг.
  - D. “Хүүхдийн эрхийг хамгаалах” сургалтад Дорж, Бат хоёр сууж мэдээлэл авсан
5. Ганчимэг багшийн анги даалтын мөнгийг ямар хэм хэмжээнд тулгуурлан шийдвэрлэсэн бэ?
  - A. Бичигдмэл бус хэм хэмжээ
  - B. Бичигдмэл хэм хэмжээ
  - C. Бичигдмэл бус хэм хэмжээ (ёс суртахуун)
  - D. Бичигдмэл бус хэм хэмжээ (зан заншил)
6. Зөрчил маргааны хоёр дахь үе шатад аль хэсэг нь хамаарч байна вэ?
  - A. Бат, Доржид буулт хийж чадалгүй өөрийн дэмждэг багийнхаа тоглогчийг бусад багуудтай харьцуулан илүү гэж зөрчилдсөөр байсан.
  - B. Тэрхүү зөрчил нь илүү хурцадмал байдалд орж Бат Доржийн хөл рүү цохиж бэртэл учруулжээ.
  - C. Нэгнийхээ дэмждэг багийн тоглогчийг хэн хэн нь илүү гэдэг санаан дээр зөрчилдсөнөө ойлгож эхэлсэн.
  - D. Доржийн ээж, аав нь Батын эцэг эхтэй уулзаж тэрхүү зөрчил маргааныг шийдвэрлэсэн.
7. Зөрчил маргааны дөрөв дэх үе шатад аль хэсэг нь хамаарч байна вэ?
  - A. Нэгнийхээ дэмждэг багийн тоглогчийг хэн хэн нь илүү гэдэг санаан дээр зөрчилдсөнөө ойлгож эхэлсэн.
  - B. Бат Доржид буулт хийж чадалгүй өөрийн дэмждэг багийнхаа тоглогчийг бусад багуудтай харьцуулан илүү гэж зөрчилдсөөр байсан.
  - C. Тэрхүү зөрчил нь илүү хурцадмал байдалд орж Бат, Доржийн хөл рүү цохиж бэртэл учруулжээ.
  - D. Доржийн ээж, аав нь Батын эцэг эхтэй уулзаж тэрхүү зөрчил маргааныг шийдвэрлэсэн.



8. Хэм хэмжээ гэдэг ойлголтыг аль хэсэг нь бүрэн илэрхийлж байна вэ?
- A. Бусад хүнтэй, байгальтай, эд юмстай харилцах харилцааг журамлаж, зөв сайхан амьдрах арга ухаанд суралцах зүйлийг эцэг, эхийн хүмүүжлээр сурсан.
  - B. Аливаа зүйлд шударга, шударга бус, ашигтай, ашиггүй гэх мэт олон янз байдал байдгийг өвөө, эмээгийнхээ сургаал номлолын үндсэн дээр сурсан.
  - C. Тухайн хичээлийн мэдлэгийг өөрт таарч буй асуудлаа зөв шийдэх арга хэрэгсэл болгож чаддаг.
  - D. Тэр хичээл бүр дээрээ өөрийн сурах арга барилд тулгуурлан суралцдаг. Тухайлбал: Бусдыг хүндэтгэх, бусадтай зөв ойлголцох арга чадвар юм.
9. Хэл ярианы соёл гэдэг ойлголтыг аль хэсэг нь бүрэн илэрхийлж байна вэ?
- A. Тухайн хичээлийн мэдлэгийг өөрт таарч буй асуудлаа зөв шийдэх арга хэрэгсэл болгож чаддаг.
  - B. Тэр хичээл бүр дээрээ өөрийн сурах арга барилд тулгуурлан суралцдаг. Тухайлбал: Бусдыг хүндэтгэх, бусадтай зөв ойлголцох арга чадвар юм.
  - C. Аливаа зүйлд шударга, шударга бус, ашигтай, ашиггүй гэх мэт олон янз байдал байдгийг өвөө, эмээгийнхээ сургаал номлолын үндсэн дээр сурсан.
  - D. Бусад хүнтэй, байгальтай, эд юмстай харилцах харилцааг журамлаж, зөв сайхан амьдрах арга ухаанд суралцах зүйлийг эцэг, эхийн хүмүүжлээр сурсан.

Дараах тохиолдлыг уншаад 10-11 дүгээр даалгаврыг гүйцэтгээрэй.

Дондог нийгэм судлалын багшаар ажилладаг. Түүний сарын цалин 1 сая 500 мянган төгрөг. Мөн Дондогийн нэг сарын хүнсний хэрэглээ нь дунджаар 150 мянган төгрөг, бусад хэрэглээ нь 40 мянган төгрөг болдог. Харин эрүүл мэндийн, авто тээвэр, англи хэлний сургалтын төлбөр гэх мэт үйлчилгээнд 220 мянган төгрөг төлдөг.

10. Дондогийн нийт хэрэглээ болон зарлага нь хэдэн төгрөг болж байна вэ?
- A. Нийт хэрэглээ 190 мянга, зарлага нь 220 мянга
  - B. Нийт хэрэглээ 220 мянга, зарлага 190 мянга
  - C. Нийт хэрэглээ болон зарлага нь 410 мянга
  - D. Нийт хэрэглээ 150 мянга, зарлага 260 мянга
11. Нийт хэрэглээг тооцоход ямар ямар үзүүлэлтүүдийг ашигладаг вэ?
- A. Хүнсний хэрэглээ + Хүнсний бус хэрэглээ + Баялаг
  - B. Хүнсний хэрэглээ + Хүнсний бус хэрэглээ + Үйлчилгээ
  - C. Хүнсний хэрэглээ + Хүнсний бус хэрэглээ + Нөөц баялаг
  - D. Хүнсний хэрэглээ + Үйлчилгээ + Нөөц баялаг

Дараах тохиолдлыг уншаад 12-13 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Болд 14 настай хөл бөмбөг тоглодог бөгөөд өөрийнхөө дэмждэг хөл бөмбөгийн багийнхаа өмсгөлийг ааваасаа төрсөн өдрийн бэлгэд авсан. Болдын хөл бөмбөгийн өмсгөлийг тамирын багш нь хараад ямар гоё өмсгөл вэ гэж уулга алдав. Мөн хөл бөмбөг сонирхдог бас тоглодог ангийнх сурагчид нь тэр өмсгөлийг Болдод маш гоё зохиж байна гэж хэлэв.

Мэдээж хүн бүхэнд биелүүлэхийг хүсдэг олон зүйл байдаг. Болдын нэг хүсэл нь дэмждэг багийнхаа тоглолтыг очиж үзэх юм.

12. Хэрэгцээ гэсэн ойлголтыг илэрхийлж байгаа хэсгийг олоорой.
- A. Болд 14 настай хөл бөмбөг тоглодог бөгөөд өөрийнхөө дэмждэг хөл бөмбөгийн багийнхаа өмсгөлийг ааваасаа төрсөн өдрийн бэлгэд авсан.
  - B. Мэдээж хүн бүхэнд биелүүлэхийг хүсдэг олон зүйл байдаг. Болдын нэг хүсэл нь дэмждэг багийнхаа тоглолтыг очиж үзэх юм.
  - C. Болдын хөл бөмбөгийн өмсгөлийг тамирын багш нь хараад ямар гоё өмсгөл вэ гэж уулга алдав.
  - D. Мөн хөл бөмбөг сонирхдог бас тоглодог ангийнх сурагчид нь тэр өмсгөлийг Болдод маш гоё зохиж байна гэж хэлэв.
13. Дээрх эхэд эдийн засагт хэрэглэгч гэж нэрлэдэг ойлголтод хэнийг хэлж байна вэ?
- A. Болдын аав
  - B. Өмсгөл зарсан худалдагч
  - C. Болд
  - D. Тамирын багш
14. Дараах өгөгдлүүдийн аль нь нийтийн өмчид хамаарах вэ?  
*Өгөгдөл: /1-Гэр, 2-Орон сууц, 3-Гар утас, 4-Мэгээд Жанрайсаг бурхан, 5-Нийтийн тээвэр/*
- A. 1, 5
  - B. 2, 5
  - C. 3, 5
  - D. 4, 5
15. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.  
Хүүхдийн эрхийг хамгаалах хууль, дүрэм журам, үйл ажиллагаанд удирдлага болгох үзэл баримтлал, үндсэн чиглэлийг ..... гэнэ.
- A. хүүхдийн эрх
  - B. хүний эрхийн зарчим
  - C. хүүхдийн эрхийн зарчим
  - D. хүний эрхийн тухай үзэл баримтлал
16. Нэр авах, улсын харьяат байх, эрүүл өсөх, хүчирхийллээс ангид байх нь таны аль эрхэд хамаарах вэ?
- A. Амьдрах эрх
  - B. Оролцооны эрх
  - C. Хөгжих эрх
  - D. Хамгаалуулах эрх
17. Дараах жишээнүүдээс аль нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчимд хамаарах вэ?
- A. Хурдан морь унадаг хүүхдийг хамгаалах зорилгоор тусгай хувцас өмсгөх
  - B. Анги хамт олон доторх асуудлыг шийдвэрлэхдээ хүүхэд бүрийн саналыг сонсож байх
  - C. Шашин, шүтлэг, боловсрол, үндэс угсаагаар ялгаварлахгүй байх
  - D. Хүүхдийн тоглоомын талбай дээр барилга байшин барих шийдвэр гаргахгүй байх
18. Анги хамт олны өмнө тулгамдаж буй асуудлыг шийдэхдээ доорх тохиолдлуудаас алийг нь баримтлах ёстой вэ?
- A. Аль болох олон хүүхэд хамруулах, тэдний дуу хоолой байр суурийг сонсох
  - B. Хүүхдүүдийн дуу хоолойг сонсох, аль болох цөөн хүүхэд хамруулах
  - C. Ангийн дарга болон анги удирдсан багшийн үзэл бодлыг сонсох
  - D. Сурлага, урлаг, спортоороо тэргүүний сурагчдын үгийг сонсож, шийдвэр гаргуулах



**19. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.**

Сургуулийн сурагчдаас сонгогдсон төлөөлөгчид нь ..... юм.

- |                        |  |
|------------------------|--|
| A. сурагчдын зөвлөл    | C. сурагчдын өөрийн удирдлагын байгууллага |
| B. сургуулийн дугуйлан | D. сургуулийн клуб                         |

**20. Сурагчийн өөрийн удирдлагын байгууллагын тухай ойлголтуудаас аль нь илүүц вэ?**

- A. Сурагчийн өөрийн удирдлагын байгууллага нь эцэг эхийн өмнө сурагчдын эрх ашгийг хамгаална
- B. Сурагчийн өөрийн удирдлагын байгууллага нь багшийн өмнө сурагчдын эрх ашгийг хамгаална
- C. Сурагчийн өөрийн удирдлагын байгууллага нь сургуулийн өмнө сурагчдын эрх ашгийг хамгаалахгүй
- D. Сурагчийн өөрийн удирдлагын байгууллага нь үйл ажиллагаагаараа сургуулийн амьдралд оролцох эрхтэй